Эдийн Засгийн Газарзүйн Байршлаас Хамаарсан Сумын Төвийн Үүргийн Ялгаа (Булган аймгийн жишээн дээр)

Д.Хишигдорж
Шинжлэх Ухааны Академи, Газарзүй, Геоэкологийн хүрээлэн
khishigdorj.davaakhuu@gmail.com

Abstract

In line with the three magnets law, the pull-and-push process of urbanization is rapidly increasing in Mongolia. As a result, the role and functions of some settlement have changed. A population growth in the larger cities has an effect of a territorial expansion of the settlements. One of the reasons for the migration of pastoral herders towards the urban centers is their interest in intensive farming business. We conducted this study in an area where rapid infrastructure development has been observed attracting intense migration to the cities.

Keywords: socio-economic geographical location, Migration, distribution population, rural settlement, social services

ОРШИЛ

Сумын төв нь малчдад үйлчлэх хамгийн ойр буюу захиргаа, сургууль, дотуур байр, цэцэрлэг, эмнэлэг [1] гэсэн үйлчилгээний үүрэг гүйцэтгэж буй боловч зарим нэг нь энэ үүргээ гүйцэтгэж чадахгүй бусад сумын төвд алдаж, хүн ам нь шилжих хөдөлгөөнөөр явж, эзэнгүйдэх тохиолдол цөөнгүй [5] байна.

Энэхүү өгүүлэлд нийгэм эдийн засгийн газарзүйн байрлал (аймгийн төв болон хатуу хучилттай авто замын алслалт)-аас хамаарч, сумын төвийн улс орны нийгэм, эдийн засагт гүйцэтгэж буй үүргийн өөрчлөлтийг тодорхойлох оролдлого хийсэн болно.

СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ

Булган аймгийн Баяннуур, Орхон, Рашаант, Хангал сумын нутагт хээрийн судалгааг нарийвчлан явуулсан (Хүснэгт 1) ба хүн амын тооны өөрчлөлт, сумын төвийн хүн амын тооны өөрчлөлт, нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь, эдийн засгийн идэвхтэй хүн амын тооны өөрчлөлт, ажил эрхлэлтийн түвшин, шилжих хөдөлгөөнд оролцогчдын тоо, багшийн тоо зэрэг статистик мэдээг тайлант оноор харьцуулж, сумын нийгэм эдийн засгийн газарзүйн байрлал (аймгийн төвийн алслалт, уул уурхайн олборлолт үйлдвэрийн алслалт, авто замын алслалт-тай уялдуулан сонгосон болно.

Хээрийн судалгааны явцад санамсаргүй түүврийн аргаар сонгосон 162 малчин өрх, 100 сумын төвийн өрхөөс 4 бүлгийн 30 асуулттай социологийн асуулга судалгаа авч, Excel программ дээр асуулт тус бүрийн хариултыг кодлосон. Үүнээс газар өмчлөн өргөн хэрэглээний барааны худалдан авалт, суралцагчдын суралцаж буй сургуулийн байршлыг хувиар илэрхийлж бодсон.

Сумын төвийн гэр хорооллын өөрчлөлтийг зураг зохиохдоо сумын төвийн гэр хорооллын хашаа, хорооны бүртгэлийн гудамж дундуур явж тэмдэглэн (шилжих хөдөлгөөнд оролцсон байдал, суурьшлын хэлбэр, суурьшлын хэлбэр) бүдүүвч зураг буулган, Google earth-н агаар сансрын 2007 оны зурагтай давхцуулж, ArcGIS программ дээр зохиосон.

Судалгаанд хамрагдсан нутгийн тойм

Монгол Улсын нийт нутгийн 3.1 хувийг эзлэх Булган аймгийн 16 суманд нийт улсын хүн амын 1.9 хувь (60.01 мянга) нь амьдарна. Хүн амын 49.7 хувь (29.8 мянга) суурин газарт оршин сууж байгаагаас 2015 хувь (12.2 мянга) аймгийн төвд, 29.4 хувь

(17.6 мянга) сумын төв, тосгонд оршин сууна. Сумын төвүүдийн 6.7 хувь (1) нь аймгийн төвөөс 40 хүртэл км-т, 20 хувь (3) нь 40-80 км-т, 73.3 хувь (11) нь 80-аас дээш км-т оршино. Хатуу хучилттай авто зам дээр 5 (31.3%) сумын төв орших бол 3 (18.8%) сумын нутгаар хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг.

ХҮСНЭГТ 1. СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сумын нэр	Аймгийн төвөөс алслагдсан зай (км)	Хүн ам	Хүн амын тооны өөрчлөлт (2005-2015)			Нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь	Дэд бүтэц		Төсвийн орлогого, зарлагын харьцаа	Үйлчилгээ	
			Нийт хүн ам	Сумын төв	Хөдөө		Хатуу хучилттай зам	Боловсрол		Шатахуун түгээх станц	Дэлгүүрийн тоо
Баяннуур	176	1868	+	-	+	52.5	+	ББД	-	+	9
Орхон	22	3482	+	-	+	57.9	-	ББД		-	4
Рашаант	250	3141	-	-	+	48.8	+	БД	-	+	23
Хангал	113	4548	+	-	+	29.1	-	ББД	+	+	4

ҮР ДҮН

2005-2015 онд судалгааны нутгийн хүн ам 4.8 хувь (МУ-ын хүн ам 18.7 хувь)-иар өссөн байхад суурин газрын хүн ам 0.3 хувь (МУ-ын суурин газрын хүн ам 17.7 хувь)-иар өсчээ. Сумын төвийн хүн амын өсөлт нийт хүн амын өсөлтөөс хэд дахин бага байгаа нь гаднаас малчид ус, бэлчээрийн таатай байдал, сумын төвийн хүн ам уул уурхайн төвүүд, томоохон хот руу шилжин суурьшиж буйтай холбоотой (Бүдүүвч 1) [7] юм.



Бүдүүвч 1. Хүн амын тоо, тооны өөрчлөлт
Эх сурвалж: Аймгийн статистикийн эмхэтгэл 1985-2015

Сумын төвийн хүн ам аажим өсч буй боловч нийгэм эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалж өсөлт нь харилцан адилгүй (Зураг 1) байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед тус аймгийн сумын төвийн хүн ам тасралтгүй өсч байсан бол зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр өсөлт нь удааширчээ. Тухайлбал дэд бүтэц харьцангуй давуу хөгжсөн Булган, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Рашаант сумын төвийн хүн ам өсч, газар тариалан голлон эрхлэх хойд сумдад тогтвортой, мал аж ахуй эрхлэх урд талын сумдад сумын төвийн хүн ам тасралтгүй буурч байна.

Хот суурин буюу сумын төвийн үйлчилгээний үүрэгт аж ахуйн, нийгмийн, ажил хэргийн, хувь хүнд үзүүлэх үүрэг [3]-үүд орох боловч зөвхөн нийгмийн үйлчилгээ (боловсрол, эрүүл мэнд)-г илэрхийлэх мэдээ материалыг Үндэсний Статистикийн Хороо, аймаг, сумын статистикийн мэргэжилтнүүдээс авч болно. Харин бусад үүргийг тодорхойлох мэдээ материалын олдоц муу байсан тул малчин болон сумын төвийн айл өрхүүдээс тусгайлан бэлдсэн социологийн асуулгаар цуглууллаа.



1985/1990 1990/1995 1995/2000 2000/2005 2005/2010 2010/2015

Зураг 1. Сумын төвийн хүн амын тооны өөрчлөлт
Эх сурвалж: Аймгийн статистикийн эмхэтгэл 1985-2015

Аймгийн төвийн хүн амыг татах орон зай буюу аймгийн төвөөс алслагдсан зайнаас хамаарч сумын төвүүдийн улс орны нийгэм эдийн засагт гүйцэтгэх үйлчилгээний үүрэг өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл алслагдсан сумын төв нь аймгийн төвтэй ойр орших сумын төвөөс илүү үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал өргөн хэрэглээний өдөр тутмын хүнс, өргөн хэрэглээний бараагаа хаанаас худалдан авдаг вэ гэж малчин болон сумын төвийн өрхүүдээс асуухад аймгийн төвтэй хил залган орших Орхон сумын судалгаа авсан нийт өрхийн 60 хувь нь аймгийн төвөөс гэж хариулсан бол Рашаант суманд 85 хувь нь сумын төвөөс худалдан авалт хийдэг гэж хариулжээ. Харин аймгийн төвөөс 113 км-т, Эрдэнэт хотоос 45 км-т орших Хангал сумын судалгаанд хамрагдсан өрхийн 83.9 хувь нь Эрдэнэтээс гэж хариуллаа (Хүснэгт 2).

Хатуу хучилттай авто зам сумын төвийг дайран өнгөрөхөд сумын төвийн үүрэг нэмэгдэнэ. Тухайлбал авто зам сумын төвөөр нь дайрсан сумын малчид сум бүлийн зориулалтаар газар өмчилж авах сонирхол бусад сумдаас илүү буюу малчид суурин амьдрал руу шилжих эрмэлзэл нэмэгдэнэ (Хүснэгт 3).

ХҮСНЭГТ 3. АВТО ЗАМЫН ДАЙРАЛТ БАЙДЛААС ХАМААРСАН МАЛЧИН ӨРХИЙН ГАЗАР ӨМЧЛӨЛ ЭХ СУРВАЛЖ: ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ (2014-2015)

Сумын нэр	Асуулга авсан өрхийн тоо	Газар өмчилж авсан эзлэх хувь	Газар өмчилж аваагүй өрхийн эзлэх хувь
Баяннуур	40	40	60
Орхон	40	20	80
Рашаант	40	40	60
Хангал	42	19	81
Бүгд	162	29.6	70.4

ХҮСНЭГТ 2. ӨРХИЙН ХУДАЛДАН АВАЛТЫН ХУВААРИЛАЛТ ЭХ СУРВАЛЖ: ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ (2014-2015)

Сумын нэр	Асуулга авсан өрхийн тоо	Сумын төв	Эзлэх хувь	Аймгийн төв	Эзлэх хувь	Эрдэнэт	Эзлэх хувь	Улаанбаатар	Эзлэх хувь
Баяннуур	60	22	36.7	0	0	0	0	38	63.3
Орхон	60	22	36.7	36	60	2	3.3	0	0
Рашаант	80	68	85	0	0	0	0	12	15
Хангал	62	8	12.9	0	0	52	83.9	2	3.2
Бүгд	262	120	45.8	36	13.7	54	20.6	52	19.9

Мөн бид сургуулийн насны хүүхэдтэй 88 малчин өрхийн асуулгад дүн шинжилгээ хийхэд авто зам сумын төвөөр дайран өнгөрч буй сум (Рашаант, Баяннуур)-д асуулганд хамрагдсан нийт малчдын 95.8 хувь нь хүүхдээ сумын сургуульдаа сургаж байна. Харин аймгийн төвтэй ойр орших Орхон суманд асуулгад хамрагдсан өрхийн 70 хувь нь аймгийн төвийн сургуульд сургадаг (Хүснэгт 4) гэж хариулжээ.

ХҮСНЭГТ 4. СУРАЛЦАГЧДЫН ЕБС-Д ХУВААРИЛАГДСАН БАЙДАЛ ЭХ СУРВАЛЖ: ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ (2014-2015)

Сумын нэр	Асуулга авсан өрхийн тоо	Сумын төв	Эзлэх хувь	Аймгийн төв	Эзлэх хувь	Эрдэнэт	Эзлэх хувь	Улаанбаатар	Эзлэх хувь
Баяннуур	18	16	88.9	0	0	0	0	2	11.1
Орхон	22	4	20	14	70	2	10	0	0
Рашаант	30	30	100	0	0	0	0	0	0
Хангал	20	12	60	0	0	8	40	0	0
Бүгд	88	62	70.5	14	15.8	10	11.4	2	2.3

Гэр хорооллын тэлэлтийг тодруулах судалгааг аймгийн төвтэй ойр орших Орхон, Улаанбаатарыг баруун болон хангайн бүсийн аймгуудтай холбох Рашаант сумын төв дээр хийлээ.



Зураг 2. Орхон сумын төвийн гэр хорооллын өөрчлөлт
Эх сурвалж: Хээрийн судалгааны материал (2014)

Орхон суманд 2007 оноос хойш нүүж явсан өрхийн хашаа байхгүй, байшингийн туурь үлдсэн байсан. 115 өрхийн хашаа хорооны бүртгэлээр 84.3 хувь (97 өрх) нь уугуул, 16.7 хувь (18 өрх) нь шилжиж ирсэн өрх байсны 4 өрх нь хашаагаа барьж амжаагүй өрх байлаа. Нийт өрхийн 93 хувь (107 өрх) нь жилийн турш амьдардаг, 7 хувь (8 өрх) нь зөвхөн өвлийн улиралд их гэрээрээ ирж өвөлждөг малтай өрхүүд байлаа.

Сумын төв малчиддаа үйлчилж чадаж байгаа эсэхийг тодруулах асуулга судалгаанаас тухайн сумын хүн ам аймгийн төв рүү татагдаж, сумын төв үйлчилгээний үүргээ гүйцэтгэж чадахгүй байгааг тодорхойлсон.



Зураг 3. Рашаант сумын төвийн гэр хорооллын өөрчлөлт
Эх сурвалж: Хээрийн судалгааны материал (2015)

Рашаант сумын төвд 2007 оноос хойш нүүж явсан 5 айлын хашаа байхгүй байсан ба 88 өрхөд судалгаа хийхэд 88.6 хувь (78 өрх) нь уугуул айл, 11.4 хувь (10 өрх) нь шилжиж ирсэн айл байлаа. Сумын төв нь малчиддаа үйлчилж чадаж байгаа эсэхийг тодруулахаар малчин өрхөөс авсан социологийн асуулгын хариултуудаас аймгийн төвөөс алслагдсан, улсын чанартай авто зам дээр орших сумын төвүүд үйлчилгээний үүргээ хангалттай гүйцэтгэж чадаж байгааг харж болно.

Рашаант сумын малчин Батсайхан, 43 настай ($47^0$21'59.9" $103^0$44'48.5")
Аймгийн төв рүү огт явдаггүй, өнгөрсөн жил том охиноо конкурс өгөхөд нэг явсан. Сумаас аймаг явдаг тээврийн шугам ч байдаггүй. Заавал Улаанбаатар орж, тэндээс унаанд суудаг. Өвөрхангайн эмнэлэг Бүс дундын оношилгооны төв учраас эмчилгээ болон төрөх үедээ Өвөрхангай л явдаг.

Манай улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарь оновчтой биш байгаагаас шалтгаалж, тухайн аймгийн алслагдсан сум өөр аймгийн төвд татагдаж байна. Тухайлбал Хангал сумын асуулганд хамрагдсан малчин өрхийн 28.6 хувь нь суурин газарт өөрийн эзэмшлийн орон сууц, хашаа байшинтай байсны 16.7 хувь нь Хялганат тосгонд, 33.3 хувь нь сумын төвд, үлдсэн 50 хувь нь Эрдэнэт хотод байна. Хүүхдээ хаана сургадаг вэ гэж асуухад 40 хувь нь Эрдэнэт хотод гэж хариулжээ. Иймд тус сумын төв нь өөрийн аймгийн төвийн үйлчлэхгүй зайд оршиж буй ч Эрдэнэт хотын хөдөө аж ахуйн бүс болж байна. Иймдээ ч хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэгцээг хангах зорилготой хөдөөгийн худ ам тасралтгүй өсч байна. Харин Баяннуур сумын төвөөр хөндлөн чиглэлийн мянгаан зам дайран өнгөрөх болсноор Улаанбаатар луу татагдах хандлага ажиглагдсан тул илүү дэлгэрэнгүй нарийвчилсан судалгаа хийх шаардлагатай байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Суурин газар (сумын төв) гэдэг нь хүн байнга буюу түр хугацаагаар амьдран суух материал баялгийг бүтээх, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах төв [3] юм. Хот суурин замын сүлжээ нэгдэж газарзүйн байрлал сайжруулснаар орчныхоо нутгийг өөртөө татаж [2] хөгждөг тул тээврийн сүлжээгээр холбогдсон хот суурингууд хөгжил нөхцөлөөр бусдаас илүү [6] байдаг. Манай улсад хөдөөгийн жижиг сумын төвүүд бүс нутаг болон улс орны хөгжлийн дүр төрхийн илэрхийлж байгаа нь өнөөгийн хотжилтын үндсэн шинж юм.
1990-ээд оноос хойш сумын төвүүд газарзүйн байршлын давуу талыг ашиглаж хөгжиж байна. Тухайлбал аймгийн төвд ойролцоо орших сумын төвүүд дагуул хот болж, том зах зээлийг ашиглаж бүтээгдэхүүнээ борлуулах төдийгүй эдийн засаг, худалдааны нягт уялдаа холбоог үүсгэж байна [4]. Өөрөөр хэлбэл аймгийн төвтэй ойр сумын малчид нь мал аж ахуйн таваарлаг салбарыг голлон өсгөж, сумын төвийнхөн төмс хүнсний ногоо тариалснаар хавсарга салбарыг эрхлэх хот орчмын бүс нутаг болж (Хүснэгт 5) байна.

ХҮСНЭГТ 5. ХАА САЛБАРЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД (2010-2015)

Аймгийн төвөөс алслагдсан зай	Хөдөөгийн хүн амын тооны өөрчлөлт	Малын тооны өөрчлөлт* (хувиар)	Хураан авсан нийт ургацад төмс, хүнсний ногооны эзлэх хувь (2015)
Баяннуур	25.4	64.2	0.28
Орхон	28.2	64.9	33.1
Рашаант	5.7	61.3	1.2
Хангал	36.4	15.6	16.3
Булган	**12.1**	**42.6**	**20**

*-Хонин толгойд шилжүүсэн коффициентийг МУ-ын үндэсний атласаас ашиглав
(Эх сурвалж: Аймгийн статистикийн эмхтгэл 2010, 2015, Үндэсний атлас)

Харин аймгийн төвөөс алс орших боловч сумын төвөөр улсын чанартай авто зам дайрахад тухайн аймгийн төвдөө татагдахгүй, өөрөө бие дааж хөгжих төлөв ажиглагдаж, ойр орчмын сумуудыг өөртөө татаж байна. Одоогоор эдгээр сумдад ойр орчмын сумуудаас хүн ам шилжин ирснээр төвлөрөл бий болж, Улаанбаатарт ирэх шилжилтийг сааруулахад зохих үүрэг гүйцэтгэж байна.

Манай улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн хуваарь оновчтой биш байгаагаас шалтгаалж, тухайн аймгийн алслагдсан сум өөр аймгийн төвд татагдаж буй олон сумууд байна. Иймд аймгийн төвөөс алслагдаж, өөр аймагт татагдан хөгжиж буй болон дан ганц малчдад үйлчлэх засаг захиргааны үүрэг гүйцэтгэж буй сумдыг илрүүлж, засаг захиргаа нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч байна.

ДҮГНЭЛТ

Хот орчмын бүс бүрэлдэж байгаатай уялдан хүн амын эрхлэж байгаа ажил төрлийн үүрэгт өөрчлөлт оржээ. Авто зам дээр орших суурин газрууд хөгжихийн хирээр хүн амын төвлөрөл нэмэгдэж байна. Имйд сумдыг аж ахуйн төрөлжилтөөр нь хөгжүүлж, үүргийн бүтцийг илүү боловсронгуй болгосноор засаг захиргаа нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг хийхэд дөхөм болно.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хийхэд үнэтэй зөвлөгөө харамгүй хайрласан “Хүн амын нутагшил суурьшлын орон зайн зүй тогтол” сэдэвт ажлын удирдагч, захирал (PhD) Б.Батбуян, сэдвийн зөвлөх (ScD) Д.Базаргүр, доктор Ж.Оюунгэрэл (PhD) болон салбарын судлаачиддаа талархал илэрхийлж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

[1] Баттулга, Х. (2013) “Зуун чухал сэдэв-Шинэ сум төсөл”

[2] Баянтөр, М. (1970) “БНМАУ-ын хот суурины хэвшлийн асуудалд” МОГЗА №10, УБ

[3] Баянтөр, М., Батцэнгэл, В., Одхүү, Н., Уранчимэг, Г., Юмчмаа, Г. (2012) “Газарзүй III сурах бичиг” УБ

[4] Н.В.Зубаревич (2003) “Социально развития ренионов Россий проблемы и тэнденций переходного периода Москва

[5] Оюун, Л. (2012) “Хаяад нүүхэд хайран нутаг минь” Өдрийн шуудан сонин 2012.11.26

[6] “Монгол орны хүн амын нутагшилт, хотжилтын орчин үеийн асуудал, төв тэнхлэгийн жишээн дээр” сэдэвт ажлын тайлан (2005-2007)

[7] “Монгол орны нийгэм эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх газарзүйн үндэслэл” сэдэвт ажлын тайлан (2008-2010)